



МОНГОЛ УЛС  
ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2025 оны 02 сарын 14 өдөр

Дугаар А/109

Чойбалсан

Г “Эрдэм” төслийг хэрэгжүүлэх тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.3, 60.1.5, Боловсролын ерөнхий хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.7, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2020 оны 01 дүгээр тогтоолоор батлагдсан “Дорнод аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 3.1.3, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны 03 дугаар хуралдааны 03/04 тогтоолоор батлагдсан “Дорнод аймгийн 2025 оны Хөгжлийн жилийн төлөвлөгөө”-ний 1.1.2, тус хуралдааны 03/04 дүгээр “Аймгийн 2025 оны төсөв батлах тухай” тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн багшийн хөгжлийг дэмжих “Эрдэм” төслийн удирдамжийг нэгдүгээр хавсралтаар, төсвийн задаргааг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Төслийг хэрэгжүүлэх зардалд шаардагдах 30,000,000 (гучин сая) төгрөгийг аймгийн Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 оны төсвийн жилд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтын 2.4 дахь “Багшийн хөгжлийг дэмжих “Эрдэм” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх” зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (П.Бат-Өлзий)-д зөвшөөрсүгэй.


3.Аймгийн Боловсролын газар (Ч.Ариунаа)-тай байгуулах “Орон нутгийн төсөв”-өөс дэмжлэг үзүүлэх гэрээг боловсруулан батлуулж, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс (Б.Нарангэрэл), Санхүү төрийн сангийн хэлтэс (В.Цэнгэлмаа)-т тус тус даалгасугай.

4.Хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлж, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулан, хэрэгжилтийг олон нийтэд танилцуулж ажиллахыг аймгийн Боловсролын газар (Ч.Ариунаа)-т даалгасугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Ч.Ганбат)-д үүрэг болгосугай.


ЗАСАГ ДАРГА

Ш.ЁЛ



2125310269

Аймгийн Засаг даргын 2025 оны  
02 дугаар сарын 14-ны өдрийн  
А/109 дугаар захирамжийн нэгдүгээр  
хавсралт



## ДОРНОД АЙМГИЙН БАГШИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ "ЭРДЭМ" ТӨСЛИЙН УДИРДАМЖ

### НЭГ. ҮНДЭСЛЭЛ

Монгол улсын Их Хурлын 2015 оны 12 дугаар тогтоолоор баталсан "Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого (2014-2024)"-д "Багшийн мэргэжлийн ур чадвар, нэр хүнд, ёс зүй, шаардлага, хариуцлагыг өндөржүүлэн, хөдөлмөрийг бодитой үнэлэх тогтолцоог бүрдүүлнэ, боловсролын мэргэшсэн удирдах болон бусад ажилтныг хүний нөөцийн төлөвлөлт, бодлоготой уялдуулан сургаж бэлтгэх, дадлагажуулах, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ" гэж заасан. Мөн "Багшийн хөгжлийг дэмжих тухай" хуулийн зорилтод "Багш бэлтгэх, багшийн хөгжил, оролцоог дэмжих, ёс зүй, нэр хүнд, нийгмийн баталгааг хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино" хэмээн тодорхойлсон.

Хөтөлбөрийг "Алсын хараа-2050" Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Дорнод аймгийн 2016-2025 оны хөгжлийн хэтийн зорилт, Аймгийн Засаг даргын 2025-2028 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичгийг үндэслэн боловсруулав.

Дорнод аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар 2020 онд батлагдсан багшийн хөгжлийг дэмжих "Эрдэм" хөтөлбөр нь багшийн мэргэжлийг дээшлүүлэх, багшийн оролцоо, нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан бөгөөд уг хөтөлбөр 2024 онд дуусаж байна. Дорнод аймагт 2024-2025 оны хичээлийн жилд цэцэрлэгт 274 багш, ерөнхий боловсролын сургуульд 900 багш ажиллаж байна. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багш нарын боловсролын болон мэргэжлийн зэрэг 2021 оноос хойш жил бүр тогтмол өссөн. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн магистр зэрэгтэй багшийн тоо 2020 онд 240 байсан бол 2024 онд 302 болж өссөн. "Зөвлөх" мэргэжлийн зэрэгтэй багшийн тоо 2020 онд 16 байсан бол 2024 онд 37 болж нэмэгдсэн нь "Эрдэм" хөтөлбөрийн үр дүн гэж үзсэн.

2020-2024 онд хэрэгжүүлсэн багшийн хөгжлийг дэмжих "Эрдэм" хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар сэтгэл ханамжийн судалгаа, цаашид хэрэгжүүлэх төсөлд оруулах ажлын санал авч, нэгтгэн чиглэлийг гаргасан.

### ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦАА:

2025 оны 01 дүгээр сараас 12 дугаар сард

## ГУРАВ. ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

Боловсролын чанарыг дээшлүүлэхэд уламжлалт сургалтын арга зүйг дэвшилтэт техник технологитой хослуулан хэрэгжүүлэх, салбарын гадаад, дотоод харилцааг бэхжүүлэх, багшийн ур чадварыг тасралтгүй дээшлүүлж, тэдний нийгмийн асуудал, амьдралын чанарыг сайжруулахад дэмжлэг болно.

## ДӨРӨВ. ТӨСЛИЙН ЗОРИЛТ

- ✓ Зорилт 1. Багш нарт сургалтын шинэ технологи, асуудлыг шийдвэрлэх арга зүйг хөгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх
- ✓ Зорилт 2. Боловсролын гадаад, дотоодын болон орон нутгийн мэргэжлийн хөгжлийн бүлгийн хамтын ажиллагаа, харилцааг өргөжүүлэхэд дэмжлэг үзүүлэх
- ✓ Зорилт 3. Багш нь боловсролын чанар хүртээмжийг нэмэгдүүлэхэд аймаг болон сургууль дээрх мэргэжлийн хөгжлийн бүлгийн ажлаар хамтран, шинэ санаа гарган инноваци хөгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх
- ✓ Зорилт 4. Багш боловсон хүчнийг мэргэшүүлэх, ахмад багш нарын туршлагыг нутагшуулах, хамтын ажиллагааг хөгжүүлэх, дэмжих

## ТАВ. ТӨСЛИЙН ЗОРИЛТЫГ ХАНГАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

**Зорилт: 1.** Багш нарт сургалтын шинэ технологи, асуудлыг шийдвэрлэх арга зүйг хөгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх

1.1. Багшийн мэргэжил, чадвараа дээшлүүлэх сургалтын төрөл, хэлбэрийг дэмжин "Дорнодын боловсрол" зөвлөгөөн зохион байгуулах

1.2. Цахим контент, цахим хичээл бэлтгэх, хөгжүүлэх, багшийг мэдээлэл харилцаа холбоо технологид суурилан сургалт явуулах арга зүйд сургах

1.3. Багш нарын мэдээлэл харилцааны технологийг эзэмших ур чадварыг нэмэгдүүлэх, цахим хичээлийн сан бүрдүүлэх, сургалтын шинэлэг технологи, арга зүйг туршин нэвтрүүлэх тэгш боломжийг олгох

**Зорилт 2.** Боловсролын гадаад, дотоодын болон орон нутгийн мэргэжлийн хөгжлийн бүлгийн хамтын ажиллагаа, харилцааг өргөжүүлэхэд дэмжлэг үзүүлэх

2.1. Боловсролын чанарыг дээшлүүлэх замаар төрөл бүрийн хэлбэрээр сургалт зохион байгуулж, үр дүнг тооцох

2.2. Багш нарыг гадаад, дотоодод мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулах, улс, олон улсын чанартай мэргэжлийн уралдаан, тэмцээнд оролцох, туршлага судлахад дэмжлэг үзүүлэх

2.3. Боловсролын чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхэд олон улсын байгууллагын төсөл хөтөлбөрийг орон нутагтаа хэрэгжүүлсэн багш, боловсролын байгууллагад орон нутгаас тодорхой дэмжлэг үзүүлэх

**Зорилт 3.** Багш нь боловсролын чанар хүртээмжийг нэмэгдүүлэхэд аймаг болон сургууль дээрх мэргэжлийн хөгжлийн бүлгийн ажлаар хамтран, шинэ санаа гарган инноваци хөгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх

3.1. Багш нарын санаачлан хэрэгжүүлж буй төсөл, ном, гарын авлагыг хэвлэх, шилдэг арга зүйг нэвтрүүлэхэд шаардагдах техник хэрэгсэл, кабинет, тоног төхөөрөмжийн зардалд дэмжлэг үзүүлэх

3.2. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүд төрийн болон иргэний нийгмийн байгууллагуудтай хамтын ажиллагааны гэрээ байгуулан, иргэний боловсрол, хүний хөгжлийн төлөө хамтран ажиллах

**Зорилт 4.** Багш боловсон хүчнийг мэргэшүүлэх, ахмад багш нарын туршлагыг нутагшуулах, хамтын ажиллагааг хөгжүүлэх, дэмжих

4.1. Удирдах ажилтны манлайлал, ур чадварыг тасралтгүй дээшлүүлэх, ахмад багш, удирдах ажилтны зөвлөх үйлчилгээг нэвтрүүлж, ахмад, залуу багшийн хамтын ажиллагааг дэмжих, ахмад багшийн туршлагыг нутагшуулахад бодитой дэмжлэг үзүүлэх

4.2. Судалгаанд суурилан дутагдалтай мэргэжлээр өөрийн сум, орон нутгаас багш бэлтгэхэд анхаарч, сургалтын төлбөрийн 80 хүртэлх хувийн тэтгэлэг, хөнгөлөлт үзүүлэх зэргээр, хүний нөөцийн бодлогыг сум бүр хэрэгжүүлэх

#### **ЗУРГАА. ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ**

- Багшийн мэргэжлийн зэргийн өсөлт /хувиар/
- Мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдсан багш нарын тоо
- Аймаг, улс, олон улсын багшийн мэргэжил, ур чадварын уралдаанд багш нарын үзүүлсэн амжилт, ур дун
- Цахим хичээл, контент ашигладаг багшийн тоо
- Сайн туршлагаа, шилдэг бүтээл туурвиж, тугээн дэлгэрүүлсэн багшийн тоо
- Сургалтын чанарын өсөлт /хувиар/

#### **ДОЛОО. ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН, ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ**

Боловсролын газар нь хэрэгжилтийн тайланг холбогдох журмын дагуу аймгийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэст тайлагнана.

---оОо---

Аймгийн Засаг даргын 2025 оны  
02 дугаар сарын 14-ны өдрийн  
А/109 дугаар захирамжийн хоёрдугаар  
хавсралт



БАГШИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ “ЭРДЭМ” ТӨСЛИЙН  
2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ШААРДАГДАХ ТӨСВИЙН ЗАДАРГАА

| №    | Хэрэгжүүлэх үйл ажиллагаа                                                                                                        | Шаардагдах төсөв |
|------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------|
| 1    | “Дорнодын боловсрол- зөвлөгөөний үйл ажиллагааг зохион байгуулах зардал                                                          | 3.0 сая          |
| 2    | Мэргэжлийн хөгжлийн бүлгийн хамтын ажиллагаа, харилцааг өргөжүүлэх, шилдэг арга зүйг шалгаруулах                                 | 6.0 сая          |
| 3    | Боловсролын салбарын удирдах ажилтан, багш нарын санаачлан хэрэгжүүлж буй төсөл, эрдэм шинжилгээний бүтээлийг түгээн дэлгэрүүлэх | 7.0 сая          |
| 4    | Боловсролын чанарыг дээшлүүлэх чиглэлээр арга зүй, технологи нэвтрүүлсэн багшийн сургалт зохион байгуулах                        | 5.0 сая          |
| 5    | Олон улс, үндэсний хэмжээний сайн туршлагаас суралцах                                                                            | 7.0 сая          |
| 6    | Багшийн хөгжлийг дэмжих “Эрдэм” төслийг олон нийтэд сурталчлан таниулах                                                          | 2.0 сая          |
| НИЙТ |                                                                                                                                  | 30.0 сая         |

---oOo---